



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН
САНХҮҮЖИЛТИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ ДҮГНЭЛТ ГАРГАХ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-НА

Баруун-Урт хот 2024 он



Газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Оюунболд

Утас: 70512127 Цахим хаяг: Oyunboldg@audit.gov.mn

Аудитор О.Барчидгүнсэн

Утас: 70512127 Цахим хаяг: Barchidgunseno@audit.gov.mn

Аудитор Б.Мөнхбамбар

Утас: 70512127 Цахим хаяг: Munkhbambarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ХЭСГИЙН ХОРООНЫ ТООТОЙ УЯЛДУУЛАН, ҮНДЭСЛЭЛТЭЙ ХУВААРИЛЖЭЭ.....	4
1.1. Сонгуулийн ерөнхий хороо, улсын бүртгэлийн ерөнхий газар, цагдаагийн ерөнхий газраас сонгууль зохион байгуулахад шаардлагатай төсвийг хууль болон журмын дагуу хуваарилсан байна.....	4
БҮЛЭГ 2. СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХУВААРИЛСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ, ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ.	5
1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.....	5
ДҮГНЭЛТ: 6	
Зөвлөмж: 6	
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	7

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УИХ	Улсын Их Хурал

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийв.
Аудитын зорилт	УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Үүнд: • УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх; • УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын сонгуулийн хороод, Улсын бүртгэлийн газар, аймгийн Цагдаагийн газрыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оюунболд, аудитор О.Барчидгүнсэн, Б.Мөнхбамбар нар гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ХЭСГИЙН ХОРООНЫ ТООТОЙ УЯЛДУУЛАН, ҮНДЭСЛЭЛТЭЙ ХУВААРИЛЖЭЭ.

1.1. Сонгуулийн ерөнхий хороо, улсын бүртгэлийн ерөнхий газар, цагдаагийн ерөнхий газраас сонгууль зохион байгуулахад шаардлагатай төсвийг хууль болон журмын дагуу хуваарилсан байна.

1.1.1 УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 /Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:/, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан журмын дагуу улсын төсвөөс олгох хөрөнгийг аймгийн сонгуулийн хороо болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах албан хаагчийн тоо зэрэгт үндэслэн тооцож 632.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

1.1.2 Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодод Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан журмын 2-р хавсралтын 2.3 дахь заалт болон Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн зааварчилгааны дагуу санал авах байр бэлтгэх, шуудан холбоо, бичиг хэрэг, албан хаагчдын урамшуулал, унааны, болзошгүй зардалд дараах байдлаар төсвийг хуваарилсан байна.

Хүснэгт №1

Д/д	Сумдын нэр	Дарга, гишүүн, даамлын тоо	Хэсгийн тоо	Олгосон санхүүжилт
1	Асгат	38	4	30,806.72
2	Баяндэлгэр	54	6	44,112.80
3	Дарьганга	40	4	32,262.08
4	Мөнххаан	54	5	42,726.08
5	Наран	32	3	25,424.00
6	Онгон	56	5	43,811.36
7	Сүхбаатар	52	5	41,517.44
8	Түвшинширээ	50	5	40,062.08
9	Түмэнцогт	22	2	17,624.00
10	Уулбаян	46	5	37,521.44
11	Халзан	38	4	30,930.08
12	Эрдэнэцагаан	75	8	60,378.80
13	Баруун-Урт	99	9	76,886.00
	Нийт дүн	656	65	524,062.88

Нийт олгосон санхүүжилтийн 82.8 хувь буюу 524.1 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороонд хуваарилсан байна.

1.1.3. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2¹, 10.3²-т заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газраас аймгийн Улсын бүртгэлийн газарт 70.3 сая төгрөг, Цагдаагийн газарт 43.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

¹ Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

² Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

БҮЛЭГ 2. СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ХУВААРИЛСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТ, ЗАРДЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖЭЭ.

1.2. Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

1.2.1. Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор 632.3 сая төгрөгийн санхүүжилт олгосноос аймгийн сонгуулийн хороо 108.2 сая төгрөгийг зарцуулж 5.0 сая, Онгон сумын сонгуулийн хэсгийн хороо 43.8 сая төгрөг зарцуулж 0.005 сая төгрөгийн үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт төвлөрүүлсэн байна. Бусад сумдын сонгуулийн хэсгийн хороо үлдэгдэл санхүүжилтгүй батлагдсан төсөвтөө багтаан зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.2.2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор санал авах байр тохижуулах зардалд 20.1 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд худалдан авсан цаашид ашиглах боломжтой материалыг сумын ЗДТГ-т хүлээлгэн өгсөн байна.

1.2.3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/24 дугаар тушаалаар Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 65.4 сая төгрөгийг хуваарилсан. Үүнээс улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны мөнгөн урамшуулал, хоолны зардалд 43.2 сая, сонгогчдын нэрсийн жагсаалт хэвлэхэд шаардагдах бичиг хэргийн материалын зардалд 4.2 сая, сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг санал авах байранд хүргэх буцаан татах зардал 6.4 сая, томилолтын зардалд 10.4 сая, сургалт сурталчилгааны зардал 1.2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.2.4. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/104 дугаар тушаалаар сонгуулийн санал авах байруудыг улсын бүртгэлийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох, тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийх 4.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хуваарилсан. Уг зардлыг 51 хэсгийн хорооны үүрэн холбооны сүлжээний хэвийн ажиллагааг шалгах унаа болон шатахууны зардалд зарцуулжээ.

1.2.5. Аймгийн Цагдаагийн газар хуваарилагдсан санхүүжилтээс шуудан холбооны зардалд 10.5 сая, унааны зардалд 2.0 сая, томилолтын зардалд 8.1 сая, албан хаагчдын хоолны зардалд 22.8 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж тайлан, судалгааг Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлсэн байна.

1.2.6. Аймгийн сонгуулийн хороонд 632.3 сая төгрөгийн санхүүжилт хуваарилснаас 627.3 сая төгрөгийг дараах 12 төрлийн зардалд зарцуулсан байна. Нийт зардлын 71.5 хувь буюу 449.0 сая төгрөгийг сонгуулийн байгууллагын ажилчдын урамшуулал болон хоолны зардалд, 7.7 хувь буюу 48.3 сая төгрөгийг унааны зардалд, 20.8 хувь буюу 130.0 сая төгрөгийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

1.2.7. Сонгууль зохион байгуулахтай холбоотой гарсан зардлын гүйцэтгэлийг батлагдсан маягтын дагуу үнэн зөв тайлагнаж, дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	1,714.00	1,553.80	160.20
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	45,777.00	43,361.00	2,416.00
3	Дүн мэдээ дамжуулах зардал	1,300.00	1,300.00	-
4	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	20,150.00	20,149.50	0.50
5	Сургалт, сурталчилгааны зардал	35,416.00	34,553.25	862.75
6	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	449,051.80	449,051.8	-
7	Бичиг хэргийн зардал	11,050.00	10,732.45	317.55
8	Шуудан холбооны зардал	12,700.00	12,438.38	261.62
9	Унааны зардал	48,286.00	48,286.00	-
10	Шуурхай багийн зардал	2,130.00	1,781.00	349.00
11	Болзошгүй зардал	4,740.20	4,067.52	672.68
НИЙТ ДҮН		632,315.00	627,274.70	5,040.30

1.2.4. Аймгийн сонгуулийн хорооноос СЕХ-ны 2021 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3.10³-т заасны дагуу сумын сонгуулийн хороодод сонгууль зохион байгуулахтай холбогдуулан олгосон санхүүжилтийг зарцуулах зааварчилгаа боловсруулж, хүргүүлсэн байна. Мөн аймгийн Сонгуулийн хорооны гишүүд сумдын сонгуулийн хороодод хяналт шалгалт, сургалт хийх, арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг ажлаар 2 удаа ажилласан байна. Халзан, Наран сумдад мэргэжлийн бус хүнийг нягтлан бодогчоор томилон ажиллуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3⁴ дахь заалт, СЕХ-ны батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 3.3, 3.3.1, 3.3.2 дэх заалтуудтай нийцэхгүй байна. сайжирна

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Сонгууль зохион байгуулахтай холбоотой хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг холбогдох маягтын дагуу тайлагнаж хэвшсэн байна.

Зөвлөмж:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СЕХ-ны даргын баталсан журмын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж аймаг, нийслэлийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдуулан сумын хэсгийн хороодод мэргэжлийн нягтлан бодогч ажиллуулах.

³ СЕХ нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.

⁴ Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



СҮХБААТАР АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

201 тоот, 2 давхарт, Нутгийн удирдлагын ордон, 7
дугаар баг, Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: 70512024

Цахим шуудан: ssonguuliinhoroo@gmail.com

2024.07.25 № 221

танай _____-НЫ _____-Т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын дүгнэлт болон зөвлөмжтэй танилцаж, хүлээн зөвшөөрсөн болно.

СОНГУУЛИЙН ХОРООНЫ
ДАРГА

П.МӨНХЖАРГАЛ

ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Холбогдох байгууллагаас ирсэн саналд тайлбар байхгүй.